

МОНГОЛ ХЭЛЭНД ЕРӨНХИЙ ГАНЦ ТОО ЗААЖ БУЙ НЭР ҮГИЙГ АНГЛИ ХЭЛНЭЭ ОРЧУУЛАХ ЯВЦАД ҮҮСЭХ ЗАРИМ АСУУДАЛ

(Англи хэлний орчуулагчийн 2-р курсын оюутнуудын жишээн дээр)

Т. Мягмарсүрэн³⁸

Товч утга: Энэхүү судалгаа нь монгол хэлэнд ганц тоо зааж буй ерөнхий нэр үгийг англи хэлэнд хэрхэн дүйцүүлэн орчуулж байгааг харьцуулан судлах зорилготой. Тус зорилгын дагуу монгол, англи хэлэнд нэр үгийн ганц тоо зааж буй өгүүлбэрийн гишүүд хоёр хэлэнд хэлзүйн хувьд хэрхэн хэлбэржиж байгааг судаллаа. Судалгаанд англи хэлний орчуулагчийн хоёрдугаар курсын оюутнуудын төлөөллийг хамруулав. Судалгааны үр дүнд 1) суралцагчдад монголоос англиар орчуулахад хэлзүй, үг сонголт, найруулга, өгүүлбэр дэх үгсийн байрлалын бэрхшээлийн аль аль нь байна, 2) суралцагчид монгол хэлний нэр үгийн ганц тоо зааж тэг бүтээврээр илэрч буй өгүүлбэрийн гишүүдийг англи хэлэнд ижил хэлбэрээр орчуулах хандлагатай байна.

Түлхүүр үг: тэг бүтээвэр, ялгац гишүүн, нэр үгийн хэлзүйн хэлбэр, орчуулах арга

Сэдвийн үндэслэл

Монгол хэлнээс англи хэлэнд мэдээлэл орчуулахад олон асуудал тулгардгийн нэг нь нэр үгийн ганц ба олон тоо билээ. Ялангуяа монгол хэлэнд ганц тоо зааж буй ерөнхий нэр үгийг англи хэлний өгүүлбэрт зөв хэлбэржүүлэх явдал юм. Монгол хэл нь алтай язгуурын, харин англи хэл нь энэтхэг-европ хэлний ангилалд тус тус багтдаг тул эдгээр нь төрөл бус хэл болох бөгөөд хоёр хэлний өгүүлбэр дэх үгсийн байрлал, үйл ба нэр үгийн хэлзүйн хэлбэр гэх мэт хоорондоо ялгаатай талууд олон. Энэ нь монгол хэлнээс англи хэлэнд орчуулга хийхэд зарим бэрхшээлийг дагуулж байдаг. Түүнчлэн монгол, англи хоёр ард түмний соёл иргэншил, уламжлал, зан заншил, сэтгэхүйн онцлог, ялгаа гэх мэт бусад хүчин зүйл орчуулгад нөлөөлөх нь бий.

Бид мэдээлэл солилцохдоо өгүүлбэрийн тусламжтайгаар төгс ойлголцолд хүрдэг. Аль ч хэлний өгүүлбэр нь өгүүлэгдэхүүн, өгүүлэхүүн гэсэн гол хоёр гишүүн болон бусад дэд гишүүдээс бүрдэнэ. Өгүүлбэрийн гол хоёр гишүүний нэг болох өгүүлэгдэхүүн нь англи, монгол хэлний алинд ч ихэнхдээ нэр үгээр илрэх ба монгол хэлний нэр үг өгүүлбэрт орохдоо өгүүлэгдэхүүн, тусагдахууны үүрэг гүйцэтгэж хэлзүйн тоо, тийн ялгал, хамаатуулахын нөхцлөөр хувирна. Монгол хэлний нэр үг

³⁸ ОУУБИС, Англи хэлний тэнхим, доктор

өгүүлбэрт тоогоор хэлбэржихдээ олон тоо үүсгэх бүтээврүүдийн тусламжтайгаар олон тоог заах бол тэг бүтээврээр ганц тоог зааж хэрэглэгдэнэ. Монгол хэлний өгүүлбэрт тэг бүтээврээр илэрсэн өгүүлэгдэхүүн болон тусагдахуун гишүүнийг англи хэл рүү орчуулахад англи хэлний ялгац гишүүний хэлзүйн дүрмийг баримтлах шаардлага урган гарна. Эндээс англи хэлний ялгац гишүүн хэмээх монгол хэлний үгсийн аймагт байдаггүй нэгэн шинэ ойлголттой бид гарцаагүй тулгардаг. Энэ шинэ гишүүн нь биднийг англи хэлээр бусадтай харилцах үед бэрхшээл болдог. Монгол хэлэнд нэр үгийн ерөнхий ганц тоо заах тэг бүтээврийг англи хэлний ялгац гишүүнтэй дүйцүүлэн судлах нь энэ сэдвийн үндэслэл болж байна.

Оршил

Байгаль ертөнцийн хүн амьтан, юмс үзэгдлийг шууд нэрлэн зааж тоо, тийн ялгал, хамаатуулахын нөхцөлөөр хувилан өгүүлбэрт ихэвчлэн өгүүлэгдэхүүн тусагдахууны үүрэг гүйцэтгэдэг нэр үгсийг жинхэнэ нэр гэнэ. Монгол хэлний жинхэнэ нэр нь ерөнхий ганц ба олон тооны эсрэгцэл дээр тулгуурласан тоон айтай. Нэр үгийн олон тооны –нар, -чууд /-чүүд/, -чуул /-чүүл/, -д, -с, -нууд /-нүүд/, -ууд /-үүд/, -уул /-үүл/ зэрэг нөхцлүүд бий. Тухайлбал, ... *Хойноос буутай хуягууд нэхэж байгаа гэсэн Гончигийн дууг таниад шууд мордлоо....* , ... *Амьдралын замд гарч яваа залуу хүмүүст хэрэг болж магад....* (Ч. Лодойдамба “Гэрээслэл”) гэсэн дээрх хоёр өгүүлбэрт *хуягууд, хүмүүс* гэсэн үгс –ууд, -с гэсэн олон тооны нөхцлөөр хувирсан байна. Гэвч олныг заах эдгээр бүтээвэртэй харьцуулбал, монгол хэлэнд ерөнхий ганц тоог илрүүлэх ил бүтээвэр байхгүй, тэг нөхцлөөр илэрнэ³⁹. Жишээлбэл, *Суумагц аагтай давстай, тос даасан шаргал цай өгч, хуруу зузаан өрөм, бэлцийсэн цагаан ааруул өмнө минь тавив.* (Ч. Лодойдамба “Гэрээслэл”) гэсэн энэ өгүүлбэрт *цай, өрөм, ааруул* гэсэн гурван нэр үг орсон бөгөөд эдгээр нь тус өгүүлбэрт шууд тусагдахууны үүрэг гүйцэтгэж, гурвуул заахын тийн ялгалын тэг хувилбараар илэрсэн байна. Цай, өрөм, ааруул гэсэн нэр үгсийн өрөм, ааруулыг нэг, хоёр, гурав хэмээн тоолж болох ба бидний нүдэнд үзэгдэж, гарт баригддаг бодот зүйлс юм. Цай гэсэн нэр үг нь үзэгдэж харагдаж, гарт барьж болох бодитой зүйл боловч түүнийг ширхэглэн тоолох боломжгүй билээ. Гэхдээ цайг аягалсан байвал аягыг нь, савласан бол савыг тоолж болдог. Хэдийгээр тэг бүтээврийг дээрх жишээгээр тайлбарлаж байгаа ч ер нь тэг бүтээвэр гэж юу юм, хэл шинжлэлийн үүднээс судлаачид юу гэж тодорхойлдог вэ гэдэг асуулт гарч ирнэ. Бүтээврийн тэг хувилбар гэдэг нь ил (бодот) бүтээврийн үүрэг гүйцэтгэж байгаа хоосныг хэлнэ. Монгол хэлэнд хэлэхийн хэмнэл, ялгах, үл ялгахын ёс зэргээс шалтгаалж ил бүтээвэр нь тэг хувилбараар илрэх ёс бий.⁴⁰ Жишээлбэл, *Манай ахынхтай нийлж нэгдлийн мянга шахам хонь хариулдаг байлаа.* (Ч. Лодойдамба “Гэрээслэл”) гэсэн өгүүлбэрт “хонь” хэмээх үг хэлний хэмнэлээс хамаарч заахын тийн ялгалын тэг хувилбараар илэрсэн байна. Монгол хэлэнд дараах

³⁹Төмөртогоо Д. Санжаа Ж нар. Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Монгол судлалын сургууль, Монгол хэл шинжлэлийн тэнхим. Орчин цагийн монгол хэл. Улаанбаатар. 2004. 131.

⁴⁰Төмөртогоо Д. Санжаа Ж нар. Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Монгол судлалын сургууль, Монгол хэл шинжлэлийн тэнхим. Орчин цагийн монгол хэл. Улаанбаатар. 2004. 105.

тохиолдолд нэр үгс нь олон тооны нөхцөл авахгүйгээр ганц тооны тэг нөхцлөөр илэрнэ. /Хүснэгт 1 /

Хүснэгт 1. Монгол хэлний нэр үгийн тэг бүтээврийн хэрэглээ

	Хэрэглэх тохиолдлууд	Жишээ
1	ширхгээр тоолж болох бодот юмсыг заахад	хурга, тугал, тэрэг, аяга
2	ширхгээр тоолж болшгүй бодот юмсыг заахад	гурил, будаа, ус, тос
3	хийсвэр ухагдахуун заахад	мөрөөдөл, мэдлэг, ухаан, сэтгэхүй
4	оноосон нэр үгс	Завхан, Ургамал, Хүнгий, Тас хайрхан, Дорж
5	хос юмсыг заасан нэр үгс	гутал, оймс, гар, нүд
6	ертөнцөд байх цорын ганц зүйлийг заасан нэр үгс	нар, сар
7	өмнөө ерөнхий олныг заасан нэр үгс	олон адуу, зарим хүн
8	тодорхой тоо заасан тодотголтой нэр үгс	мянган хонь, арван тэмээ
9	хурах, цуглах, тарах, бэлчих, хураах, түүх зэрэг үйлийг гүйцэтгэх болон эзний нэр	
10	өөр өөр ном, хэд хэдэн чулуу, бөөн бөөн тоглоом гэх мэт тодотголтой нэр үгс	

Монгол хэлний тэг бүтээвэр англи хэлэнд байдаг уу, байдаг бол хэрхэн илэрдэг вэ? Бид яаж таньж болох вэ? Монгол хэлнээс англи хэл рүү үүнийг орчуулахдаа хэлзүйн ямар зарчмыг баримтлах вэ? Англи хэлэнд монгол хэлний тэг бүтээвэртэй адил өгүүлбэрт ижил төсөөтэй үүрэг гүйцэтгэдэг эс тухайлах ялгац гишүүн болон тэг ялгац гишүүн гэсэн хоёр гишүүн бий. Тус хоёр ялгац гишүүнээс гадна гуравдахь нь буюу тухайлах ялгац гишүүн гэж байдаг. Англи хэлний эс тухайлах болон тэг ялгац гишүүд монгол хэлний тэг бүтээвэртэй төсөөтэй хэлзүйн зарчим баримталдаг нь аль аль нь нэр үгтэй хамт хэрэглэгддэг явдал юм. Эхлээд англи хэлний эс тухайлах ялгац гишүүн хэлзүйн ямар үүрэгтэй болохыг дараах жишээгээр авч үзье. Эс тухайлах ялгац гишүүн нь өгүүлбэрт нэр үгийн ганц тоог зааж “a”, “an” гэсэн ил бүтээврээр илэрдэг. Жишээ нь, *He was an old man who fished alone in a skiff in the Gulf Stream and he had gone eighty-four days now without taking a fish.* (Ernest Hemingway “The old man and the sea”). Тус өгүүлбэрт *an old man, a skiff, a fish* гэсэн гурван нэр үгийн өмнө “a”, “an” гэсэн ил бүтээврүүд орж нэг гэсэн утгыг илэрхийлсэн байгаагаас үзвэл англи хэлний ил бүтээвэр “a”, “an” нь ширхэглэн тоолж болох бодот нэр үгтэй хамт хэрэглэгдэж байгаа нь илт байна. Хэл судлаачид англи хэлний эс тухайлах ялгац гишүүнийг ямар ямар тохиолдолд, яаж хэрэглэж болох талаар дурдсаны заримыг Хүснэгт 2-оор үзүүлье.

Хүснэгт 2. Англи хэлний эс тухайлах ялгац гишүүн “a”, “an” –н хэрэглээ

	Хэрэглэх тохиолдлууд	Жишээ
1	ширхгээр тоолж болох бодот юмсыг заахад	a kid, an eraser, an egg
2	хийсвэр ухагдахуун заахад	We have a new student today.
3	оноосон нэр үгс	I am a Mongolian.
4	нэг долоо хоног, сар, жил, зуунд гэж ярихад	I brush my teeth twice a day.
5	“1” гэсэн цифрийн утгыг илэрхийлэхэд	I bought a kilogram of flour.
6	ажил мэргэжлийг заахад	He is a student.

7	what гэсэн үгтэй хамт гайхсан санааг ирэлхийлэхэд	What a high heel!
8	such гэсэн үгтэй хамт нэр үгийг хүч нэмэгдүүлэхэд	I never know you were such a good student.

Англи хэлний өгүүлбэрт нэр үгийн ганц тоог эс тухайлах ялгац гишүүн болох “a”, “an” ил бүтээврээр танихаас гадна э тэг ялгац гишүүн буюу тэг бүтээврээр ялгаж болно. Жишээлбэл, *Many of the fishermen made fun of the old man.* (Ernest Hemingway “The old man and the sea”) гэсэн өгүүлбэрт “fun” гэсэн нэр үг тэг бүтээврээр илэрч өгүүлбэрт тусагдахуун гишүүний үүрэг гүйцэтгэж байна. Монгол хэлний тэг бүтээвэртэй ижил хэрэглэгддэг англи хэлний тэг ялгац гишүүнийг хэрэглэх олон тохиолдлууд байгаагаас заримыг Хүснэгт 3-аар үзүүлж байна.

Хүснэгт 3. Англи хэлний нэр үгийн тэг ялгац гишүүн /бүтээвр/-ийн хэрэглээ

	Хэрэглэх тохиолдлууд	Жишээ
1	ширхгээр тоолж болшгүй бодот юмсыг заахад	water, milk, meal
2	хийсвэр ухагдахуун заахад	happiness, dream
3	оноосон нэр үгс (хүн, газар орон, гудамж, хэл, судалж буй шинжлэх ухааны хичээл, өдөр, сар.)	John, Mary, English, Monday
4	Хоолыг заахад	Breakfast, dinner, lunch
5	1 гэсэн тоо ширхэгийн(цифр) гэсэн бүтцэд	Chapter 1, 2, 3 ...
6	Тээврийн хэрэгслийг заахад	By car, by taxi, on foot
7	Улс болон хотуудын нэр	Russia, Seoul
8	Өмнөө төлөөний нэр заасан үгтэй хэрэглэгдэхэд	My car, his book

Англи хэлний нэр үг нь ганц тоог илэрхийлж дээрх тохиолдлуудаар илэрхээс гадна монгол хэлний нэр үгийн адилаар олон тооны нөхцөл авч хувирдаг бөгөөд англи хэлэнд нэр үгийг олон тоонд хувиргах “s” гэсэн ганцхан бүтээвр бий. Тухайлбал, *The blotches ran well down the sides of his face and his hands had the deep-creased scars from handling heavy fish on the cords.* (Ernest Hemingway “The old man and the sea”) гэсэн өгүүлбэрт орсон *blotches, sides, hands, scars, cords* гэсэн үгс олон тооны ‘s’ нөхцлөөр хэлбэржсэн байна.

Судалгааны материал, арга зүй

Энэ судалгаанд англи хэлний орчуулагчийн ангийн хоёрдугаар курсын 23 оюутны төлөөллийг хамруулж 2 төрлийн судалгааг авав. Судалгаа 1-ээр суралцагчдаас дөрвөн хүчин зүйл бүхий асуумжийг санамсаргүй түүврийн аргаар авч, үр дүнг SPSS19 программд боловсруулав. Асуумжийг 1-5 баллаар (1-хамгийн их, 2-их, 3-дунд, 2-бага, 5-байхгүй) үнэлсэн. Судалгаа 2-ын дагуу суралцагчид монгол хэлний нэр үг тэг бүтээврээр илэрсэн 10 тохиолдлыг багтаасан монгол өгүүлбэрийг англиар орчууллаа.

Судалгаа 1

Судалгаа 1-ээр монгол хэлнээс англи хэл рүү орчуулга хийхэд тохиолддог бэрхшээлийг хэлзүй, өгүүлбэр дэх үгсийн байрлал, үг сонголт, найруулга гэсэн дөрвөн хүчин зүйлээр ангилсан асуумж авлаа. Энэ судалгаагаар суралцагчдад төрөл бус хэлийг орчуулахад нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлов.

График 1. Монгол хэлнээс англи хэл рүү орчуулахад нөлөөлж буй хүчин зүйлс




График 1-ээс харахад оюутнууд маань дээрх дөрвөн хүчин зүйлсийн аль алиныг нь хялбар гэж үзээгүй байгаа нь тэд англи хэлний мэргэжлийн ангид суралцаж эхэлж байгаатай холбоотой байж болно. Судалгаанд хамрагдсан оюутнууд монгол хэлнээс англи хэл рүү орчуулахад үг сонголт, найруулга, хэл зүйн дүрмээсээ илүү өгүүлбэрт үгсийг зөв байрлуулах нь арай хялбар байна гэж үзжээ. Тус судалгааны гол зорилгод хамаарах асуумжид өгөгдсөн нөлөөлөх дөрвөн хүчин зүйлсийн нэг болох хэл зүйн бэрхшээлийг оюутнууд хэрхэн үнэлсэн байгааг авч үзэхэд, байхгүй – 0%, бага – 21,7%, дунд – 21,7%, их – 21,7%, хамгийн их 34,8% байна. Энэ нь суралцагчдад хэлзүйн дүрмийн бэрхшээл тулгарч байгааг харуулж байна.

Судалгаа 2

Судалгаа 2-оор оюутнууд монгол хэлэнд ерөнхий ганц тоо зааж буй нэр үгийг англиар хэрхэн орчуулж, ямар түгээмэл алдаа гаргаж байгааг олж тодорхойлох зорилготой. Энэхүү судалгааны ажлын гол зорилгын дагуу оюутнуудын орчуулсан өгүүлбэрээс үг сонголт, найруулга, өгүүлбэр дэх үгсийн байршилтай холбоотой алдааг түр орхин, судалгаанд өгөгдсөн дараах жишээ өгүүлбэрүүдийн зөвхөн хэлзүйн алдаанд тулгуурлах болно. Хэлзүйн алдааг тайлбарлахдаа 1) монгол хэлний нэр үгийн тэг бүтээвэр, 2) англи хэлний эс тухайлах ялгац гишүүн “a”, “an”, 3) англи хэлний нэр үгийн тэг ялгац гишүүн /бүтээвэр/, 4) англи хэлний нэр үгээс олон тоо үүсгэх “s” бүтээврийн хэрэглээг⁴¹ тус тус үндэслэл болгов. Монгол хэлний өгүүлбэрт


⁴¹Мягмарсүрэн.Т. “Монгол хэлний нэрийн үгийн ганц тоог англи хэлнээ орчуулах явцад үүсэх зарим асуудал” илтгэл, Хүснэгт 1.

өгүүлэгдэхүүн болон тусагдахуун гишүүний үүрэг гүйцэтгэж ганц тоо заасан нэр үгийг англи хэлэнд орчуулахад ямар ямар нийтлэг алдаа гарч байгааг англи хэлний орчуулагчийн ангийн хоёрдугаар курсын оюутнуудаас авсан жишээ өгүүлбэрээр үзүүлье.

Жишээ өгүүлбэр 1:

Гэр дээр тавьсан ааруулыг шувуу тоншчихоод байх юм.	Зорилтот үг	Монгол хэлний нэр үгийн ганц тооны тэг бүтээврийг хэрэглэх тохиолдол	Зорилтот үгийг дүйцүүлэн орчуулсан англи хэлний бүтээврүүд	Хэл зүйн хувьд зөв, боломжит бүтээвэр
	шувуу	Ширхгээр тоолж болох бодот юмс	“ø”, “s”, “a/an”, “the”	“s”, “a/an”

График 2. Жишээ өгүүлбэр 1-ийн үр дүн




Судалгаанд оролцсон оюунуудын 47.9% нь “шувуу” хэмээх үгийг хамгийн боломжит “s” бүтээврийг зөв сонгож хэрэглэсэн бол “a”, “an” бүтээврийг авч ашиглаагүй байна. Харин 30,4% нь монгол хэлний нэр үгийн тэг бүтээвэртэй адил хэлбэрээр, 21.7% нь тухайлах ялгац “the” сонгож алдаа гаргасан байна.

Жишээ өгүүлбэр 2:

Цагаан будаа авъя.	Зорилтот үг	Монгол хэлний нэр үгийн ганц тооны тэг бүтээврийг хэрэглэх тохиолдол	Зорилтот үгийг дүйцүүлэн орчуулсан англи хэлний бүтээврүүд	Хэл зүйн хувьд зөв, боломжит бүтээвэр
	будаа	Ширхгээр тоолж болшгүй бодот юмс	“ø”, “s”, “a/an”, “the”	“ø”

График 3. Жишээ өгүүлбэр 2-ийн үр дүн




Оюутнууд зорилтот үг “будаа”-г англи хэлэнд хэрхэн хувиргаж орчуулсан байгааг график 3-аас харахад 69.6% нь зөв бүтээврээ сонгожээ. Энэ нь будаа гэдэг үг

нь англи, монгол хэлний аль алинд нь ширхэгээр тоолж болшгүй бодот зүйлс болох учраас үгийн утгаас хамаарч ихэнх нь тэг бүтээвэр авсан байх магадлалтай. 13% нь “а” бүтээврийн сонгосон нь энэ талаар ойлголт багатай оюутнууд цөөнгүй байгааг харууллаа.

Жишээ өгүүлбэр 3:

Дүүдээ шинэ нүдний шил авлаа.	Зорилтот үг	Монгол хэлний нэр үгийн ганц тооны тэг бүтээврийг хэрэглэх тохиолдол	Зорилтот үгийг дүйцүүлэн орчуулсан англи хэлний бүтээврүүд	Хэл зүйн хувьд зөв, боломжит бүтээвэр
	нүдний шил	Хос юмсыг заасан нэр үгс	“ø”, “s”, “a/an”, “the”	“s”

График 4. Жишээ өгүүлбэр 3-ийн үр дүн




“Дүүдээ нүдний шил авлаа.” гэсэн монгол өгүүлбэрт нэр үгийн ганц тоо зааж тэг бүтээврээр илэрсэн “нүдний шил”-ийг оюутнуудын 73.4% нь зөв орчуулсан байгаа нь англи хэлэнд хос юмсыг ерөнхий ганц тоогоор биш, олон тооны нөхцлөөр хувиргадаг дүрмийг оюутнууд баримталж байна гэж үзэхээр байна. Гэвч 17.4% нь монгол хэлний тэг бүтээврээр хэлбэржсэн хэлбэрийг англи хэлэнд шууд хэрэгжүүлж алдаа гаргажээ.

Жишээ өгүүлбэр 4:

Тэднийх 20 гаруй адуу, арваад үхэртэй.	Зорилтот үг	Монгол хэлний нэр үгийн ганц тооны тэг бүтээврийг хэрэглэх тохиолдол	Зорилтот үгийг дүйцүүлэн орчуулсан англи хэлний бүтээврүүд	Хэл зүйн хувьд зөв, боломжит бүтээврүүд
	адуу	Тодорхой тоо заасан тодотголтой нэр үгс	“ø”, “s”, “a/an”, “the”	“s”

График 5. Жишээ өгүүлбэр 4-ийн үр дүн



“Адуу” гэсэн ерөнхий ганц тоо заасан нэр үгийг орчуулсан байдлыг графикаас үзвэл суралцагчдын 30.4% нь зөв бүтээврээр хувиргалаа. Суралцагчдын 69.6% нь монгол хэлний үгтэй ижил зарчмаар тэг бүтээвэр авч алджээ. Энэ нь адуу гэсэн үгний өмнө орсон хорь гаруй хэмээх тодорхой тоо заасан тодотголтой холбоотойгоор англи хэлний нэр үгийн олон тоо үүсгэх бүтээврийг хэрэглэжээ гэж үзэж болохоор байна.

Жишээ өгүүлбэр 5:

Хонь	Зорилтот үг	Монгол хэлний нэр үгийн ганц тооны тэг бүтээврийг хэрэглэх тохиолдол	Зорилтот үгийг дүйцүүлэн орчуулж болох англи хэлний бүтээврүүд	Хэл зүйн хувьд зөв, боломжит бүтээврүүд
хураачаад, тоглоорой.	хонь	Хурах, цуглах, тарах, бэлчих, хураах, түүх зэрэг үйлийг гүйцэтгэх болон эзний нэр	“ø”, “s”, “a/an”, “the”	“ø”

График 6. Жишээ өгүүлбэр 5-ийн үр дүн




“Хонь” хэмээх энэ үгийг нийт судалгаанд оролцогчдын 39.1% нь тэг бүтээврээр зөв орчуулсан байгаа бол 56.5% нь олон тоо үүсгэх ‘s’ бүтээврээр хэлбэржүүлж, алдаа гаргасан байна. Энэ нь оюутнууд англи хэлэнд ширхэглэн тоолж болдог зүйлс олон тоо заах нөхцөл авдаг гэсэн дүрмийг баримталж байгаа ч дүрмийн бусаар хувирдаг үгсийг сайн хэрэглэж мэдэхгүй байгааг харуулж байна.

Жишээ өгүүлбэр 6:

Манай нутагт өндөр өндөр уул бий.	Зорилтот үг	Монгол хэлний нэр үгийн ганц тооны тэг бүтээврийг хэрэглэх тохиолдол	Зорилтот үгийг дүйцүүлэн орчуулсан англи хэлний бүтээврүүд	Хэл зүйн хувьд зөв, боломжит бүтээврүүд
	уул	Өөр өөр ном, хэд хэдэн чулуу, бөөн бөөн тоглоом гэх мэт тодотголтой нэр үгс	“ø”, “s”, “a/an”, “the”	“s”

График 7. Жишээ өгүүлбэр 6-ийн үр дүн



Жишээ өгүүлбэр 6-д “өндөр өндөр уул” гэсэн зорилтот үгийг орчуулсан байгааг үзвэл судалгаанд оролцсон оюутнуудын 52.1% нь зөв бүтээврээ сонгожээ. 34.7% нь монгол хэлний тэг бүтээвэртэйгээ ижилхэн хэлбэржүүлж алдсан байна. Энэ нь оюутнууд англи хэлний нэр үгийн ганц ба олон тоог ялгаж салгах ойлгох тал дээр учир дутагдалтай байгааг харуулав.

Дүгнэлт болон санал

Судалгаа нэг, хоёроос гарсан үр дүнд тулгуурлан дараах дүгнэлтэнд хүрч байна. Судалгаанд оролцсон хоёрдугаар курсын оюутнуудын тухайд хэл зүй, үг сонголт, үгсийн байрлал, найруулга аль аль нь бэрхшээлтэй байна. Монгол хэлний өгүүлбэрт ерөнхий ганц тоо зааж, тэг бүтээврээр илэрч буй нэр үгсийг англи хэлээр орчуулахдаа шувуу-30.4%, будаа-69.6%, нүдний шил-17.4%, адуу-30.4%, хонь-39.1%, уул-34.7%-иар тус тус ижилхэн “s” бүтээврээр хэлбэржүүлж алдаа гаргав. Англи хэлний “the” бүтээврийг ч цөөнгүй оюутнууд сонгож алдлаа хийлээ. Судалгаанаас гарсан энэ үр дүнгээс үзэхэд оюутнууд англи хэлний тухайлах, эс тухайлах ялгац гишүүдийн хэрэглээний ялгаатай талуудыг хараахан сайн танин мэдээгүй байна. Иймд энэхүү илтгэлийн Хүснэгт 1-т үзүүлсэн монгол хэлний нэр үгийн тэг бүтээврийн хэрэглээг Хүснэгт 2, 3, 4-ийн англи хэлний нэр үгийн ганц тоо заах эс тухайлах, тэг бүтээвэр, олон тоо үүсгэх “s” бүтээврийн хэрэглээтэй харьцуулан таних боломжтой. Түүнчлэн англи хэлний тухайлах ялгац гишүүнийг хэрэглээний ялгаатай талыг ч анхаарах шаардлагатай байна.

Ном зүй

Төмөртоого Д. Санжаа Ж нар. Монгол Улсын Боловсролын Их Сургууль,
Монгол судлалын сургууль, Монгол хэл шинжлэлийн тэнхим. Орчин
цагийн монгол хэл. Улаанбаатар. 2004.

Отгонсүрэн Ц. Орчуулахад суралцах бичиг-I. Улаанбаатар. 2014

Гүн-Үйлс Д. Орчуулга, найруулга зүй. Улаанбаатар. 2012

Ч. Лодойдамба “Гэрээслэл” өгүүллэг

Ernest Hemingway “The old man and the sea”

Мягмарсүрэн Т. Монгол хэлний нэрийн үгийн ганц тоог англи хэлнээ орчуулах
явцад үүсэх зарим асуудал. Улаанбаатар. 2018